



ОРХОН АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗАР



9001:2015



37001:2016

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ОНЦЛОХ АЖЛЫН ТАЙЛАН

2026 он





ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2026 ОНЫ 1 ДҮГЭЭР САРД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар

2026 он

Д/д	Зохион байгуулсан ажлууд	Зохион байгуулсан тоо, оролцогчдын тоо	Хэрэгжилт
1.	Байцаагч, мэргэжилтнүүдийн чиг үүргийн дагуу Нийгмийн даатгалын багц хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, дүрэм зааврыг ажил олгогч, иргэд, олон нийтэд сурталчлан таниулахад чиглэсэн сургалт зохион байгуулсан.	Гадагшаа чиглэсэн 3 удаагийн сургалт, 53 ажил олгогч, иргэд, даатгуулагч	Нийгмийн даатгалын байгууллагаас шимтгэл төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын тогтвортой үйл ажиллагааг дэмжих, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хамран хэрэгжүүлэх, мэдээллээр хангах, цахим үйлчилгээний хүртээмжийг таниулах зорилгоор 3 аж ахуйн нэгж байгууллагын 53 албан хаагч, ажилчдад зөвлөгөө, мэдээлэл хүргэн ажилласан.
2.	Байгууллагын албан хаагч, ажилтнуудын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, албан хаагчдын ур чадаврыг дээшлүүлэх зорилгоор дотогшоо чиглэсэн сургалт зохион байгуулсан.	Дотогшоо чиглэсэн 8 удаагийн сургалт, давхардсан тоогоор 90 албан хаагч, ажилчид	Орхон аймгийн Прокурорын газраас прокурор Л.Энхтайван, Г.Эрдэнэзул нар эбатуудад зориулсан зөрчлийн хэрэг бүртгэлийн сисемд ажиллах практик сургалт, Орхон аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн багш Б.Ванчигням "Хиймэл оюун ухаан ашиглан видео засварлах" сэдвээр, Орхон аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн багш Г.Оюун-Эрдэнэ "Англи хэл"-ний цуврал сургалт, Орхон аймгийн Татварын газраас татварын улсын байцаагч Х.Түвшинтөгс, Т.Цэвэлсайхан

			нар "ХХОАТ-н хөнгөлөлт, чөлөөлөлт" сэдвээр мөн тус газрын архивч Н.Намуундарь "Архивын баримт үдэхэд анхаарах асуудал" сэдвээр тус тус сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 90 албан хаагч, ажилчид хамрагдлаа.
3.	Аймгийн засаг дарга Б.Зоригтбаярын иргэдтэй хийх уулзалтад оролцсон.	13 чиглэлийн 28 багийн иргэдэд мэдээлэл түгээн ажилласан	Аймгийн засаг дарга Б.Зоригтбаярын иргэдтэй хийх уулзалтад Газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нармандах болон магадлагч эмч Б.Пүрвээ нар 2026 оны 01 дүгээр сарын 19-ны өдрөөс 24-ний өдрийг хүртэл хамт оролцон иргэдээс ирсэн асуултад хариулж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Дэнж багийн нутаг дэвсгэрт оршин суух иргэний хөдөлмөрийн хэвийн бус нөхцлөөр тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг шалган холбогдох хуулийн дагуу шийдвэрлэсэн.
4.	Цахим хуудсаараа дамжуулан 2026 оны 01 сард постер, рийл, контент бэлтгэн хүргэсэн.	Нийт 34 удаагийн постер мэдээлэл, 6 удаагийн рийл, богино хэмжээний бичлэг бэлтгэн хүргэсэн. Нийт 85,059 хандалт авсан байна.	Нийгмийн даатгалын газрын цахим хуудсаараа дамжуулан Нийгмийн даатгалын хууль, тогтоомж, нийгмийн даатгалын ач холбогдолыг сурталчлах, байгууллагын үйл ажиллагаа, авлига, ёс зүйтэй холбоотой мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэх зорилгоор 01 дүгээр сард 34 удаагийн постер мэдээллийн хандалтын тоо 45,301 /давхардсан тоогоор/, 6 удаагийн рийл, богино хэмжээний бичлэгийн хандалтын тоо 29,884 /давхардсан тоогоор/ бэлтгэн хүргэсэн.
5.	Нийгмийн даатгалын хууль тогтоомжын дагуу өдөр тутмын үйл ажиллагаа явагдсан.	Нийгмийн даатгалын газраас үйлчилгээ авч буй иргэдийн тоон үзүүлэлт	Нийгмийн даатгалын газраас 2026 оны 01 сард 243 иргэнд үйлчилгээ үзүүлж, аижлгүйдлийн тэтгэмж 141 иргэнд, өндөр насны тэтгэвэр 84 иргэнд, 5 иргэнд цэргийн алба хаасны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 9, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 4 иргэнд тус тус шинээр тогтоон олгож эхэлсэн. Эрүүл мэндийн магадлалын зөвлөл 2 удаа хуралдаж 141 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэн ажилласан байна. 3109 иргэний сайн дурын даатгалтай холбоотой хүсэлтийг хүлээн авч 99,84% шийдвэрлэн ажилласан байна.
6.	Нийгмийн даатгалын газрын ирэх сард хийх ажлууд:	2025 оны баримтыг архивт хүлээлгэн өгнө, "Сэтгэл зүйн дархлаатай хамт олон" төслийн	Ирэх сард: -2025 оны үйл ажиллагааны баримтууд болон аж ахуйн нэгж байгууллагын цаасан тайланг архив хүлээлгэн өгч эхэлнэ.

		сургалтууд явагдаж хэрэгжиж эхлэнэ.	-2024 онд Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраас санаачлан хэрэгжүүлсэн "Сэтгэл зүйн дархлаатай хамт олон" төсөл нь 2025 онд Орхон аймгийн Нийгмийн бодлогын салбарын байгууллагуудад хэрэгжихээр батлагдан. 2026 оны 2 сараас эхлэн уг төслийн сэтгэл зүйн сургалтууд болон ментор албан хаагчдыг бэлтгэх сургалтууд эхэлнэ.
--	--	-------------------------------------	---

**ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2026 ОНЫ 02 ДУГААР САРД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН
АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар

2026 он

Д/д	Зохион байгуулсан ажлууд	Зохион байгуулсан тоо, оролцогчдын тоо	Хэрэгжилт
1.	Байцаагч, мэргэжилтнүүдийн чиг үүргийн дагуу Нийгмийн даатгалын багц хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, дүрэм зааврыг ажил олгогч, иргэд, олон нийтэд сурталчлан таниулахад чиглэсэн сургалт зохион байгуулсан. Нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах, нийгмийн даатгалын суурь ойлголт өгөх сургалт зохион байгуулсан.	Гадагшаа чиглэсэн 2 удаагийн сургалтад 106 сурагч	Нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах, нийгмийн даатгалын суурь ойлголт өгөх, мэдээллээр хангах, цахим үйлчилгээний хүртээмжийг таниулах зорилгоор ЕБС-н 2 сургуулийн 106 ахлах ангийн сурагчдад мэдээлэл хүргэн ажилласан.
2.	Байгууллагын албан хаагч, ажилтнуудын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, албан хаагчдын ур чадаврыг дээшлүүлэх зорилгоор дотогшоо	Дотогшоо чиглэсэн 4 удаагийн сургалт, давхардсан тоогоор 32 албан хаагч, ажилчид	Орхон аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн багш Г.Оюун-Эрдэнэ "Англи хэл"-ний цуврал сургалт, Орхон аймгийн Онцгой байдлын газрын Ангиллын сургалт, сурталчилгаа урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Ганзориг "Гал түймрийн аюулаас урьдчилан

	чиглэсэн сургалт зохион байгуулсан.		сэргийлэх арга хэмжээ", мөн галын хор, багаж хэрэгслийг зөв хэрэглэх тухай үзүүлэх сургалт зохион байгууллаа.
3.	Цахим хуудсаараа дамжуулан 2026 оны 02 сард постер, рийл, контент бэлтгэн хүргэсэн.	Нийт 8 удаагийн постер мэдээлэл хүргэн нийт 92,007 хандалт авсан байна.	Нийгмийн даатгалын газрын цахим хуудсаараа дамжуулан Нийгмийн даатгалын хууль, тогтоомж, нийгмийн даатгалын ач холбогдолыг сурталчлах, байгууллагын үйл ажиллагаа, авлига, ёс зүйтэй холбоотой мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэх зорилгоор 2 дүгээр сард 8 удаагийн постер мэдээллийн хандалтын тоо 92,007 /давхардсан тоогоор/ бэлтгэн хүргэсэн.
5.	Нийгмийн даатгалын хууль тогтоомжын дагуу өдөр тутмын үйл ажиллагаа явагдсан.	Нийгмийн даатгалын газраас үйлчилгээ авч буй иргэдийн тоон үзүүлэлт	Нийгмийн даатгалын газраас 2026 оны 02 сард 2541 иргэнд үйлчилгээ үзүүлж, өндөр насны тэтгэвэр 124 иргэнд, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 25, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 13 иргэнд тус тус шинээр тогтоон олгож эхэлсэн. Эрүүл мэндийн магадлалын зөвлөл 8 удаа хуралдаж 427иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэн ажилласан байна. 2 сард 20085 тэтгэвэр авагчид 21,4 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгон ажилласан байна. Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт 117.91 хувьтайгаар ажиллаж байна. Мөн байгууллагын санхүүгийн тайланд аудитын хяналт шалгалт хийлгэж “өөрчлөлтгүй” дүгнэлт авч ажилласан байна.
6.	Нийгмийн даатгалын газрын ирэх сард хийх ажлууд:	2025 оны баримтыг архивт хүлээлгэн өгч, тэтгэврийн архивт хувийн хэргийн тооллого хийнэ.	Ирэх сард: -2025 оны үйл ажиллагааны баримтууд болон аж ахуйн нэгж байгууллагын цаасан тайланг архивт хүлээлгэн өгч эхэлнэ. -Тэтгэврийн архивт хувийн хэргийн тооллого хийж, ЗГ-н тогтоолын нэмэгдэл хувийг хувийн хэрэгт бичилт хийн ажиллана -Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийлгэнэ.

**ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2026 ОНЫ 03 ДУГААР САРД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН
АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар

2026 он

Д/д	Зохин байгуулсан ажлууд	Зохин байгуулсан тоо, оролцогчдын тоо	Хэрэгжилт
1.	Байцаагч, мэргэжилтнүүдийн чиг үүргийн дагуу Нийгмийн даатгалын багц хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, дүрэм зааврыг ажил олгогч, иргэд, олон нийтэд сурталчлан таниулахад чиглэсэн сургалт зохион байгуулсан. Нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах, нийгмийн даатгалын суурь ойлголт өгөх сургалт зохион байгуулсан.	Гадагшаа чиглэсэн 8 удаагийн сургалтад 217 иргэд даатгуулагч, ажил олгогч	Нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах, нийгмийн даатгалын суурь ойлголт өгөх, мэдээллээр хангах, цахим үйлчилгээний хүртээмжийг таниулах зорилгоор ЕБС-н ахлах ангийн сурагчдад “Даатгалтай ирээдүй” сэдвээр сургалт зохион байгуулж, 3 сургуулийн 169 сурагчдад мэдээлэл хүргэн ажилласан. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Орхон аймаг дахь салбар танхимаас зохион байгуулсан Өглөөний менежер уулзалтад оролцож ажил олгогч нарт мэдээлэл хүргэн ажилласан бол БОЭТөвийн Төрөх, эмэгтэйчүүдийн тасаг, Сэргээн засах эмчилгээний тасгуудад сургалт зохион байгуулж, тэтгэмжийн хүсэлт цахимаар илгээх зааврыг хүргэн ажилласан.
2.	Байгууллагын албан хаагч, ажилтнуудын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, албан хаагчдын ур чадаврыг дээшлүүлэх зорилгоор дотогшоо чиглэсэн сургалт зохион байгуулсан.	Дотогшоо чиглэсэн 5 удаагийн сургалт, давхардсан тоогоор 73 албан хаагч, ажилчид	Орхон аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн багш Г.Оюун-Эрдэнэ "Англи хэл"-ний цуврал сургалт, Хүний эрхийн үндэсний комиссын Орхон аймаг дахь төлөөлөгч Ц.Батзаяа “Жендэрийн тэгш зарчим” сэдвээр, Орхон аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн эмч н.Ганчимэг "Эрүүл зөв хооллолт" сэдвээр сургалт зохион байгуулж албан хаагчдад эрүүл амьдралын хэв маяг хэвшил болгох зорилготойгоор сургалтууд зохион байгууллаа.
3.	Цахим хуудсаараа дамжуулан 2026 оны 03 сард постер, рийл, контент бэлтгэн хүргэсэн.	Нийт 24 удаагийн постер мэдээлэл хүргэн нийт	Нийгмийн даатгалын газрын цахим хуудсаараа дамжуулан Нийгмийн даатгалын хууль, тогтоомж, нийгмийн даатгалын ач холбогдолыг сурталчлах, байгууллагын үйл ажиллагаа, авлига, ёс зүйтэй холбоотой мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэх

		67,352 хандалт авсан байна.	зорилгоор 3 дугаар сард 24 удаагийн постер мэдээллийн хандалтын тоо 67,352 /давхардсан тоогоор/ бэлтгэн хүргэсэн.
5.	Нийгмийн даатгалын хууль тогтоомжын дагуу өдөр тутмын үйл ажиллагаа явагдсан.	Нийгмийн даатгалын газраас үйлчилгээ авч буй иргэдийн тоон үзүүлэлт	Нийгмийн даатгалын газраас 2026 оны 03 сард 1889 иргэнд үйлчилгээ үзүүлж, өндөр насны тэтгэвэр 165 иргэнд, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 38, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 42 иргэнд тус тус шинээр тогтоон олгож эхэлсэн. Эрүүл мэндийн магадлалын зөвлөл 3 удаа хуралдаж 210 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэн ажилласан байна. 3 сард 20,330 тэтгэвэр авагчид 21,6 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгон ажилласан байна. Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт 108.8 хувьтайгаар ажиллаж байна. Тэтгэврийн 4, Тэтгэмжийн 4, нэг цэгийн үйлчилгээний 3 байцаагч мэргэжилтэн, ТТХ-ийн дарга нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй нийт тэтгэвэр авч байгаа 19024 даатгуулагчийн хувийн хэрэгт МУЗГ-ын 2024 оны 120, 2025 оны 221, 2026 оны 242 дугаар тогтоолын нэмэгдлүүдийг бичиж ажиллаж байгаа бөгөөд 2026 оны 2 дугаар улиралд багтаж дуусгах төлөвлөгөөтэй байна. Мөн 2025 оны сангийн санхүүгийн тайланд Төрийн аудитын байгууллагын хяналт хийгдэж байна.
6.	Шинэлэг үйлчилгээ.	Хөтөч байцаагч	Нийгмийн даатгалын газраас үйлчилгээ авч буй иргэдэд зөвлөн туслах, чиглүүлэх, анхан шатны зөвлөгөө мэдээлэл хүргэх, цахим үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор “Хөтөч байцаагч” ажиллаж эхэллээ.

7	Шинэлэг сургалт.	Шимтгэлийн тайлан илгээх практик сургалт	Нийгмийн даатгалын байгууллага нь сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Лхагва гараг бүрт ажил олгогч нарт зориулсан сургалт зохион байгуулж эхэлсэн бөгөөд 3 сард 2 удаа амжилттай зохион байгууллаа. Энэ нь ажил олгогч, нягтлан бодогч, захирал, хүний нөөц нарт тулгардаг нийгмийн даатгалын тухай хуулийн ойлголт, шимтгэлийн тайлан мэдээ гаргах, тоон гарын үсгээр тайлан илгээх, нийгмийн даатгаолын цахим үйлчилгээ зэрэг түгээмэл асуудлуудад мэргэжлийн зөвлөгөө арга зүйн туслалцаа үзүүлдэг практик сургалт болдгоороо онцлогтой юм.
6.	Нийгмийн даатгалын газрын ирэх сард хийх ажлууд:	Улсын байцаагчийн шалтгалтад бэлтгэнэ.	Ирэх сард: Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, сэргээх шалтгалтад албан хаагчдыг бэлтгэх ажлын хүрээнд техникийн бэлэн байдлыг хангах, дотооддоо сургалт зохион байгуулж ажиллана.

ТАЙЛАН ХЯНАСАН:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:.....Д.НАРМАНДАХ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН:.....Н.ХУЛАН